



БАГАНУУР ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА П.БАТТУШИГ ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: soltsoг@наас.mn, Вэб сайт: http://наас.mn

2026-04-21 № 05/1327

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан Г  
мэдүүлэг хянасан тухай

Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Дашнямын Баасанбаярын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин нэр дэвшигч А.Алтанзулын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар цахим хэлбэрээр ирүүлээгүй байх тул хянан үзэх боломжгүй байна.

Цаашид тухайн албан бичигт нэр дурдсан нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг дээрх журмын дагуу цахим системд гаргаж ирүүлэхэд анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



М.ДАВААТОГТОХ



БАГАНУУР ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН  
ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2026.01.13 № 05/672

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Багануур дүүргийн Соёлын ордны захирлын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Юндэнгийн Баян-Очирын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д заасан төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад ороогүй байх тул хөлбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллана уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАВГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



М.ДАВААТОГТОХ

142603001119